



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 19/239

Улаанбаатар хот

Албан хаагчдыг байгууллагын
шагналаар шагнах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.3.7, Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журам", Байгууллагын даргын 2017 оны А/441 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 9.2.1, 9.2.3, 9.2.4, 9.5.1, 9.5.2 дахь заалт, байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан үүргээ үнэнч шударгаар биелүүлж, идэвх зүтгэл гарган ажилласан Хангалт үйлчилгээний газрын үйлчлэгч А.Туяаг "Хүндэт тэмдэг"-ээр, Зүүн бүс дэх газрын жолооч Т.Алтанпүрэвийг "Хүндэт өргөмжлөл"-өөр, Мэдээллийн технологийн хэлтсийн сүлжээний инженер С.Пүрэвчулуун, Хангалт үйлчилгээний газрын жолооч С.Батжаргал, Т.Баттулга нарыг мөнгөн шагналаар тус тус шагнаасугай.

2. "Хүндэт тэмдэг"-т дагалдах 100.000 төгрөг, "Хүндэт өргөмжлөл"-д дагалдах 50.000 төгрөг, Мөнгөн шагналд дагалдах 100.000 төгрөг, нийт дагалдах 450.000 /дөрвөн зуун тавин мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Санхүүгийн хэлтэс /Б.Даваажав/-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /М.Төрбат/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨРӨН

000001029